



ИХ/2022

Тархаасан: 2022 оны 10 дугаар сарын 14




## Улсын хилээр орсон гадаадын зорчигчид өмнөх оны мөн үеэс 194.5 мянга буюу 8.1 дахин өсжээ

Манай улсын хилээр 2022 оны эхний 9 сарын сард 1 265.2 мянган (давхардсан тоогоор) зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 776.6 (2.6 дахин) мянгаар нэмэгдсэн боловч Ковид-19 цар тахлын өмнөх үе буюу 2019 оны мөн үеийнхтэй харьцуулахад 3 458.6 (73.2%) мянгаар бага байна.

Мөн оны эхний 9 сарын байдлаар 629.4 мянган зорчигчид хилээр орсон байна. Улсын хилээр орсон зорчигчдын 36.1 хувь нь Чингис хаан, 22.1 хувь нь Алтанбулаг, 9.9 хувь нь Гашуун сухайт, 4.9 хувь нь Замын-Үүд, 4.8 хувь нь Булган, 3.0 хувь нь Шивээхүрэн, 19.2 хувь нь бусад боомтоор орсон байна.

Улсын хилээр орсон зорчигчдын 407.4 (64.7%) мянга нь Монгол Улсын иргэд, 221.9 (35.3%) мянга нь гадаад улсын иргэд байна.

ЗУРАГ 1. МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН ЗОРЧИГЧИД, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, боомтоор, дүнд эзлэх хувиар



Тайлбар: Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд байгуулагдсан "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал"-ыг "Чингис хаан" олон улсын нисэх буудал, Улаанбаатар хотын Буянт-Ухаа дахь "Чингис хаан" олон улсын нисэх буудлыг "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудал гэж тус тус 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нэрлэсэн. (Монгол улсын засгийн газрын 455 дугаар тогтоол)

Улсын хилээр 2022 оны эхний 9 сард гадаадын 221.9 мянган хүн орсон нь өмнөх оны мөн үеэс 194.5 мянга буюу 8.1 дахин нэмэгдсэн байна. Тэдний 91.9 хувь нь 30 хоног хүртэл, 3.0 хувь нь 30-90 хоног, 5.1 хувь нь 90 ба түүнээс дээш хоногийн хугацаагаар ирсэн байна.

ХҮСНЭГТ 1. МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН ГАДААД ЗОРЧИГЧИД, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, бүс нутаг, улсаар

Бүс нутаг, улсаар	2019 I-Х	2020 I-Х	2021 I-Х	2022 I-Х
<b>Нийт</b>	<b>525 623</b>	<b>60 523</b>	<b>27 426</b>	<b>221 937</b>
<b>Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг</b>	<b>324 814</b>	<b>25 387</b>	<b>8 432</b>	<b>83 623</b>
БНХАУ	166 130	15 161	5 546	9 117
БНСУ	91 345	5 483	1 234	46 274
Казахстан	13 810	1 501	602	15 313
Вьетнам	1 076	96	9	1 454
<b>Европ</b>	<b>165 078</b>	<b>32 271</b>	<b>15 592</b>	<b>122 313</b>
ОХУ	112 253	27 860	10 479	104 849
Беларусь	2 415	1 923	3 377	3 183
Герман	11 701	615	400	3 718
Франц	10 203	325	156	2 673
<b>Америк</b>	<b>23 678</b>	<b>1 698</b>	<b>1 468</b>	<b>9 493</b>
АНУ	17 467	1 289	1 274	7 970
Канад	3 843	289	135	1 079
Бразил	789	34	16	154
Мексик	205	4	2	53
<b>Өмнөд Ази</b>	<b>5 282</b>	<b>250</b>	<b>435</b>	<b>1 569</b>
БНЭУ	2 257	209	244	1 184
Балба	358	13	11	68
Пакистан	299	9	132	152
Бангладеш	171	7	39	84
<b>Ойрх Дорнод</b>	<b>4 849</b>	<b>614</b>	<b>1 228</b>	<b>3 950</b>
Турк	1 559	550	848	2 911
Израйл	1 074	20	5	293
Катар	862	11	117	110
Иран	234	19	14	206
<b>Африк</b>	<b>1 888</b>	<b>300</b>	<b>270</b>	<b>982</b>
Өмнөд Африк	1 352	251	181	718
Египет	60	2	24	36
Гана	20	9	2	15
Кени	39	9	4	18
<b>Харьяалалгүй</b>	<b>34</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>7</b>

Энэ оны эхний 9 сард улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 128.7 (58.0%) мянга нь эрэгтэйчүүд, 93.2 (42.0%) мянга нь эмэгтэйчүүд байна. Нийт зорчигчдын 203.1 (91.5%) мянга нь насанд хүрсэн хүн, 18.8 (8.5%) мянга нь хүүхэд байна.

Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 55.1 хувь нь Европ, 37.7 хувь нь Зүүн Ази, Номхон Далайн бүс нутаг, 4.3 хувь нь Америк, 1.8 хувь нь Ойрх Дорнод, 0.7 хувь нь Өмнөд Ази, 0.4 хувь нь Африк тивээс иржээ.

Хилээр орсон гадаадын зорчигчдын 47.2 хувийг ОХУ-ын иргэд, 20.9 хувийг БНСУ-ын иргэд, 6.9 хувийг Казахстан улсын иргэд, 4.1 хувийг БНХАУ-ын иргэд, 3.6 хувийг АНУ-ын иргэд, 2.3 хувийг Япон улсын иргэд, үлдсэн 15.0 хувийг бусад улсын иргэд тус тус эзэлж байна.

Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо энэ оны эхний 9 сард 211.0 мянга болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 188.3 мянгаар буюу 9.3 дахин өссөн байна. Энэ оны эхний 9 сарын байдлаар улсын хилээр орсон жуулчдыг өмнөх оны мөн үетэй зорчсон улсаар нь харьцуулж үзвэл БНХАУ-ын жуулчид 2 816 (68.5%) жуулчнаар, ОХУ-ын жуулчид 92 584 жуулчнаар (11.1 дахин), БНСУ-ын жуулчид 44 275 (44.1 дахин) жуулчнаар, Казахстан улсын жуулчид 14 642 (28.4) дахин жуулчнаар тус тус нэмэгджээ.

Манай улсын 428.7 мянган (давхардсан тоогоор) иргэн 2022 оны эхний 9 сард гадаадад зорчсоноос 227.0 (53.0%) мянга нь аялал жуулчлалын зорилгоор зорчсон нь өмнөх оны мөн үеэс 137.1 мянга буюу 2.5 дахин өссөн бол 201.6 (47.0%) мянга нь ажиллах, суралцах болон байнга оршин суух зорилгоор зорчсон нь өмнөх оны мөн үеэс 76.6 мянга буюу 61.4 хувиар өсжээ (Хүснэгт 2). Гадаадад зорчсон Монгол Улсын иргэдийн 292.2 (68.2%) мянга нь эрэгтэйчүүд, 136.5 (31.8%) мянга нь эмэгтэйчүүд байна. Тэдгээрийн 29.3 (6.8%) мянга нь хүүхэд байна. Тэдний 379.3 (88.4%) мянга нь 30 хүртэл хоног, 7 578 (1.8%) нь 30-аас 90 хүртэл хоног, 41.8 (9.8) мянга нь 90, түүнээс дээш хоногийн хугацаагаар явсан байна.


**ХҮСНЭГТ 2. ГАДААДАД ЗОРЧСОН МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, зорчсон улсаар**

Улсын нэр	2019 I-X	2020 I-X	2021 I-X	2022 I-X
<b>Бүгд</b>	<b>1 844 330</b>	<b>452 174</b>	<b>214 852</b>	<b>428 692</b>
Австрали	4 208	858	55	3 793
АНУ	11 995	2 318	3 421	9 912
АНЭУ	786	287	102	1 696
БНСУ	70 219	17 895	5 985	41 147
БНХАУ	1 369 347	353 058	186 464	172 775
ОХУ	271 378	47 569	6 164	111 977
Тайланд	5 585	1 963	26	4 758
Турк	4 585	3 003	3 820	24 042
ХБНГУ	7 914	2 204	1 508	8 629
Япон	21 809	4 604	1 322	15 329
Бусад	76 504	18 415	5 985	34 634

Улсын хилээр 2022 оны эхний 9 сард 1 063.5 мянган (давхардсан тоогоор) тээврийн хэрэгслийг нэвтрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 39.1 (3.6%) мянгаар буурчээ. Тэдгээрийн 54.1 хувийг ачааны вагон, 34.1 хувийг ачааны машин, 9.5 хувийг суудлын машин, 2.3 хувийг бусад тээврийн хэрэгсэл эзэлж байна.

Нийт тээврийн хэрэгслийн 46.3 хувь нь Замын-Үүд, 12.3 хувь нь Сүхбаатар, 11.8 хувь нь Гашуун сухайт, 9.1 хувь нь Алтанбулаг, 20.5 хувь нь бусад боомтоор тус тус нэвтэрсэн байна.

ЗУРАГ 2. МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛСЭН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, жилийн бүрийн эхний 9 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар, боомтын төрлөөр



**Аргачлалын тайлбар:**

Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдод гадаадын болон дотоодын иргэдийг хамруулав. Монгол Улсын хилээр орсон зорчигчдыг зорилгоор нь албаны, хувийн, жуулчлал, дамжин өнгөрөх, суралцах, ажиллах, байнга оршин суух, бусад гэж ангилна.

**Жуулчин:** Байнга оршин суудаг газраасаа өөр газарт албаны, хувийн, жуулчлал, дамжин өнгөрөх, бусад зорилгоор 183 хоногоос доош хугацаагаар аялж буй гадаадын иргэн юм.



**Эх үүсвэр:**

Хил хамгаалах ерөнхий газар

**Мэдээлэл авах холбоос:**

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:**

2023 оны 01 дүгээр сарын 13

Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын дарга Ш.Ариунболд  
Утас : (976-51)-261523

Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын Хүн ам, орон сууцны тооллогын хэлтсийн статистикч Ж.Пүрэвлхам  
Утас : (976-51)-260434



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212